



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа
сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэх, төсөл
дэмжигдээгүй буюу нэг жилийн хугацаанд дахин
хүлээж авахгүй байх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.5, 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.3.3, 19.3.4, 19.18, 19.20.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 6 дугаар зүйл, “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл” олгох комиссын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагын нэрсийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагыг гуравдугаар, тусгай зөвшөөрлийн хүсэлт төсөл дэмжигдээгүй байгууллагын нэрсийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Л.Зэндмаа), Чанарын хяналтын газар (Г.Номин)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА




Д.НАРАНТУЯА

1422

101249


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022
оны 12 дугаар сарын 28 ны өдрийн 1/149 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1.	ЭЙ БИ ЭЙ ЖИ СКРИЙНИНГ ХХК РД-6791697 9011834069	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	УБ хот, ЧД 18 дугаар хороо, яргайтын гудамж 37-144 тоот	2025.12.22
2.	МСМ ГРУПП ХХК РД-2560526 9019009002	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	УБ хот, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /17070/, Чингисийн өргөн чөлөө гудамж 62 тоот	2025.12.22
3.	БЮТИ СИС ХХК РД-6177468 9011670110	Эм, эмнэлгийн хэрэгсэл, Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	УБ хот, ХУД 11 дүгээр хороо, Зайсан хийлс цогцолбор, 6 дугаар давхарт	2025.12.22
4.	ДАЙМОНД ФАРМ ХХК РД-6842364 9011837708	Эм, эмнэлгийн хэрэгсэл, импортлох, ханган нийлүүлэх	УБ хот, БЗД 25дугаар хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 63Б байрны 1 дүгээр давхар	2025.12.22


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022
оны 12 дугаар сарын 23 ны өдрийн 4/16 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ
БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагууд				
1.	МӨНХИЙН ТУН ХХК РД-2024608	Эм ханган нийлүүлэх	Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, "Ач заяа" эмнэлгийн байранд	2027.11.12
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагууд				
2.	ДИАСИС МОНГОЛИА ХХК РД-5071542	Эмнэлгийн хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 5-р хороо, Самбуугийн гудамж Шуурхай зар центр 7 дугаар давхарт	2028.01.10


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
 зохицуулалтын газрын даргын, 2022
 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 1/12 дугаар
 тушаалын гуравдугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГЭХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1.✓	НАХИА ИМПЕКС ХХК РД-2048833	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	СБД, 2-р хороо, Нарны зам гудамж 18	2027.03.25
2.✓	МК БРИДЖ ПАРТНЕРС ХХК РД-6211054	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 15-р хороо, Нарны зам-18	2026.05.16
3.✓	ӨЛГИЙ ТУН ХХК РД-3077306	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх	Баян-Өлгий аймаг, Өлгий сум 5 дугаар баг, Ховд гол 1 дүгээр гудамж, Блю ский байрны 1 дүгээр давхарт	2023.06.23
4.✓	МОНОС-БАЯН ӨЛГИЙ ХХК РД-3076377	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх	Баян-Өлгий аймаг, Өлгий сум 11 дүгээр баг 145 тоот	2023.06.22

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
 зохицуулалтын газрын даргын 2022
 оны 18 дугаар 9 сарын 23 -ны
 өдрийн А/149 дугаар тушаалын дөрөвдүгээр
 хавсралт



ТӨСӨЛ ДЭМЖИГДЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад заасны дагуу 1 жилийн хугацаанд дахин хүлээн авахгүй байгууллагууд		
1.	ЛАКИЛИНК ХХК	Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх
2.	КАЗОС ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх